

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

(албан тушаал)

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

ИД. СЫМЪЯАБА3АР/

(00H20)

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТАЛСАН:

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ  
МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН  
ХҮРГИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/ M. БАРПАА/

"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОРОН  
НҮТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГА

УБСАЙНБАЯР/

|   |     |                                                                                        |                  |                  |              |                 |                      |               |
|---|-----|----------------------------------------------------------------------------------------|------------------|------------------|--------------|-----------------|----------------------|---------------|
| № | Д/д | Стратеги, төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая, төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа I-IV улирал/ | Хариуцах нэгж |
|---|-----|----------------------------------------------------------------------------------------|------------------|------------------|--------------|-----------------|----------------------|---------------|

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийн нэмэгдүүлсэн байна.



|                                                                                                                                      |       |                                                                                                                                                                                                                          |  |                                                        |       |       |              |                                                                                 |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--------------------------------------------------------|-------|-------|--------------|---------------------------------------------------------------------------------|
| 1                                                                                                                                    | 1.1.1 | 1.1.1.3 Газарт бүртгэлтэй өмчийн хөрөнгийг түрээс үйлчилгээнд гаргаж төсвийн орлого бүрдүүлнэ.                                                                                                                           |  | Өмчийн түрээсийн орлого                                | 85.0  | 100.0 | I-IV улирал  | Захиргаа, санхүүгийн алба<br>Маркетингийн алба<br>Тохижилт<br>үйлчилгээний алба |
| 4.1.3 Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай харилцалатай төлөвлөж, сахилга батыг сайжруулсан байна. |       |                                                                                                                                                                                                                          |  |                                                        |       |       |              |                                                                                 |
| 2                                                                                                                                    | 1.1.2 | 1.1.2.1 Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд төсвийг үр ашигтай төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд сар, улирлын хуваарийн саналыг бэлтгэж санхүүгийн сахилга батыг сайжруулж ажиллана. |  | -                                                      | 816.6 | 991.1 | I-IV улирал  | Захиргаа, санхүүгийн алба                                                       |
| 1.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр                              |       |                                                                                                                                                                                                                          |  |                                                        |       |       |              |                                                                                 |
| 4.1.4 Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.                |       |                                                                                                                                                                                                                          |  |                                                        |       |       |              |                                                                                 |
| 3                                                                                                                                    | 1.2.1 | 4.1.4.1 Төсвийн ерөнхийлөн Захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангуулна.                                      |  | Шилэн дансны сайтад хугацаанд нь оруулсан мэдээний тоо | 65    | 88    | I-IV улирал  | Захиргаа, санхүүгийн алба                                                       |
| 4                                                                                                                                    | 1.2.2 | "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллүүдийг ил тод, нээлттэй байлгах арга хэмжээг зохион байгуулна.     |  | Хуулийн хэрэгжилтийн хувь                              | 70%   | 90%   | I-IV улирал  | Захиргаа, санхүүгийн алба                                                       |
| 5                                                                                                                                    | 1.2.3 | Байгууллагаас түрээс үйлчилгээнд гаргах эд хөрөнгө, гэр баазын захиалгыг цахимаар авах боломжийг бүрдүүлж ажиллана.                                                                                                      |  | Цахим үйлчилгээнд хамрагдсан байгууллага.              | 0     | 50    | II-IV улирал | Маркетингийн алба                                                               |



[illegible]



|    |      |                                                                                                                                                                                            |       |                                                        |       |       |             |                           |
|----|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|--------------------------------------------------------|-------|-------|-------------|---------------------------|
|    |      | эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиглах.                                                  |       | заалтын хэрэгжилтийн хувь                              |       |       |             |                           |
| 12 | 2.3. | Хүний нөөцийг төлөвлөх, судлах, сонгох, томилох, чөлөөлөх санал боловсруулан танилцуулах, шийдвэрийн төсөл боловсруулах.                                                                   |       | Санал боловсруулсан тоо, шийдвэрийн төслийн тоо        | 83    | 83    | I-IV улирал | Захиргаа, санхүүгийн алба |
| 13 | 2.4. | Нийт ажилтнуудын ажлыг сар, улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэж, цалин хөлс, урамшууллыг олгох, Егр цаг бүртгэлийн системд хяналт тавих                                       | 641,0 | Ажил дүгнэж, цалин урамшуулал олгосон хэмжээ (сая.төг) | 602,7 | 641,0 | I-IV улирал | Захиргаа, санхүүгийн алба |
| 14 | 2.5. | Ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах, ХАБЭА-н зөрчилгүй ажиглах.                                                                                                              | 4,3   | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ(сая.төг)                   | 2,2   | 4,3   | I-IV улирал | Захиргаа, санхүүгийн алба |
| 15 | 2.6. | Газрын даргын А, Б тушаалын төслийг хянаж, хууль эрх зүйн актад нийцүүлэх                                                                                                                  |       | Хянасан тушаалын тоо                                   | 120   | 120   | I-IV улирал | Захиргаа, санхүүгийн алба |
| 16 | 2.7. | Ажил гүйцэтгүүлэх, худалдан авах болон эд материалын түрээсийн гэрээний эхийг бэлтгэн гэрээ хийх.                                                                                          |       | Байгуулсан гэрээний тоо                                | 21    | 21    | I-IV улирал | Захиргаа, санхүүгийн алба |
| 17 | 2.8. | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлуулж мөрдүүлэх.                                                                                                                        |       | Батлуулсан дотоод журмын тоо                           | 1     | 1     | I-IV улирал | Захиргаа, санхүүгийн алба |
| 18 | 2.9. | Газарт хамаарах бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, даргын зөвлөлийн хуралд танилцуулж дээд шатны байгууллагад тайлагнах. |       | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо                   | 1     | 2     | I-IV улирал | Захиргаа, санхүүгийн алба |



|    |       |                                                                                                                                                                                     |  |                                                         |      |      |               |                           |
|----|-------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|---------------------------------------------------------|------|------|---------------|---------------------------|
| 19 | 2.10. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох арга хэмжээ авах. |  | Зөрчил арилгуулсан тоо                                  | 2    | 2    | II, IV улирал | Захиргаа, санхүүгийн алба |
| 20 | 2.11  | Газрын 2022 онд хөтлөгдөж дууссан баримтыг актаар хүлээн авах хуваарь гарган батлуулж, хуваарийн дагуу архивд нөхөн баяжуулалт хийх                                                 |  | Баримтын тоо                                            | 37   | 80   | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба |
| 21 | 2.12  | Баримт нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг тогтмолжуулах, байгууллагад Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлаж, мөрдүүлэх                                               |  | Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилтийн хувь | 80   | 100  | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба |
| 22 | 2.13  | Байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөлийг улиралд 1 удаа хуралдуулж шаардлагатай үед хяналтын тооллого хийх гарсан шийдвэрийг тухай бүрт нь танилцуулж тайлагнах.               |  | Хурлаар шийдвэрлэсэн асуудлын тоо                       | 4    | 4    | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба |
| 23 | 2.14  | 2023 оны улирал, хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан гаргах.                                                                                                                       |  | Тайлан гаргасан тоо                                     | 4    | 4    | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба |
| 24 | 2.15  | 2023 оны цалингийн программ, санхүүгийн программ, шинэчлүүлэн сар бүрийн төсвийн төлөвлөгөөний хуваарийг программд шивж оруулах.                                                    |  | Гүйцэтгэлийн хувь                                       | 100% | 100% | I улирал      | Захиргаа, санхүүгийн алба |
| 25 | 2.16  | 2023 оны байгууллагын Бизнес төлөвлөгөө, Орлого бүрдүүлэлтийн төлөвлөгөө гаргаж батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах                                                              |  | Батлуулсан төлөвлөгөөний тоо, хэрэгжилтийн хувь         | 2    | 2    | I улирал      | Маркетингийн алба         |



|                                                           |      |                                                                                                                                                                            |      |                                   |      |       |               |                                                                                 |
|-----------------------------------------------------------|------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|-----------------------------------|------|-------|---------------|---------------------------------------------------------------------------------|
| 26                                                        | 2.17 | "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг бүрэн хангаж, шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх. |      | Хэрэгжилтийн хувь                 | 60%  | 100%  | III улирал    | Захиргаа, санхүүгийн алба<br>Маркетингийн алба<br>Тохижилт<br>үйлчилгээний алба |
| 27                                                        | 2.18 | Хот нийтийн аж ахуйн нэгдсэн систем UB enjineering ашиглана.                                                                                                               |      | Нэгдсэн системийн ашиглалтын хувь | 0    | 100%  | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба<br>Маркетингийн алба                                  |
| ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: |      |                                                                                                                                                                            |      |                                   |      |       |               |                                                                                 |
| 28                                                        | 3.1  | "Монгол наадам үндэсний спорт цогцолбор"-ын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний дагуу ажлын зураг гаргах ажлыг холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлах.                 |      | Арга хэмжээний тоо                | 0    | 4     | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба<br>Маркетингийн алба                                  |
| 29                                                        | 3.2  | "Эрүүл иргэн-Эко хөгжил" спорт өдөрлөг, "Хөхүүрийн айрагны баяр", "Цасны баяр" арга хэмжээг зохион байгуулна.                                                              | 56,7 | Арга хэмжээний тоо                | 0    | 3     | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба<br>Маркетингийн алба<br>Тохижилт<br>үйлчилгээний алба |
| 30                                                        | 3.3  | Нийслэлийн харьяа төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон нийтэд зориулсан соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах.                                |      | Хамрагдсан иргэдийн тоо           | 8500 | 10500 | II-III улирал | Захиргаа, санхүүгийн алба<br>Маркетингийн алба                                  |
| 31                                                        | 3.4  | "Монгол Наадам" гэр баазын үйл ажиллагааг эрчимжүүлэх, гадна дотно тохижилтыг сайжруулах.                                                                                  |      | Хийгдсэн ажлын тоо                | 1    | 2     | I-IV улирал   | Маркетингийн алба                                                               |
| 32                                                        | 3.5  | 2023 онд Мэргэжлийн болон Үндэсний спорт хороодын Хүй долоо хуудат зохион байгуулах тэмцээн уралдааны тов гаран зохион байгуулах.                                          |      | Хамрагдсан иргэдийн тоо           | 4000 | 4500  | I-III улирал  | Маркетингийн алба                                                               |
| 33                                                        | 3.6  | "Монгол Наадам Цогцолбор" ОНӨТҮГ-аарын Улсын тусгай хэрэгцээний газрын 11.089г га                                                                                          |      | Арга хэмжээний тоо                | 1    | 1     | II-IV улирал  | Маркетингийн алба                                                               |



|                                                                            |     |                                                                                                                                                                                                              |                                    |     |      |               |                           |
|----------------------------------------------------------------------------|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|-----|------|---------------|---------------------------|
|                                                                            |     | газрын ашиглалтын байдлад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах                                                                                                                         |                                    |     |      |               |                           |
| 34                                                                         | 3.7 | Үндэсний Их Баяр наадмын үеэр Хүй долоо худалт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, худалдаачид, уяачдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулан холбогдох татвар хураамжийг авч төрийн сангийн дансанд оруулах | Бүрдүүлсэн орлогын хэмжээ(сая.төг) | 7,6 | 9,0  | II-III улирал | Маркетингийн алба         |
| ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: |     |                                                                                                                                                                                                              |                                    |     |      |               |                           |
| 35                                                                         | 4.1 | Байгууллагын албан хэрэг хөтөлтийг стандартын дагуу явуулж, тайлагнах.                                                                                                                                       | Стандартын хэрэгжилт               | 90% | 100% | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба |
| 36                                                                         | 4.2 | Иргэд, аж ахуйн байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх.                                                                                                                          | Шийдвэрлэлтийн хувь                | 90% | 100% | I-IV улирал   | Захиргаа, санхүүгийн алба |

Нийт батлагдсан төсөв 991,1 сая төгрөг, Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого 100,0 сая төгрөг



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2023 оны 01 дугаар сарын 05

№

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шударга, ил тод хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар үр ашгийг дээшлүүлэх, харьяа байгууллагуудын удирдах ажилтнуудын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэхэд оршино.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, нөгөө талаас "Монгол наадам цогцолбор" Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дарга С.Сайнбаяр нар цаашид (Удирдах ажилтан), хамтад нь (Талууд) 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

1.3. "Тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас тухайн жилд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, төсөв, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, хугацаа, хариуцах нэгжийг тусгав.

1.4. Талуудын хооронд байгуулсан энэхүү гэрээтэй холбогдох харилцааг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн зохицуулна.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын хүлээх үүрэг

2.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангана.

2.3. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд сахилга, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авна.

2.4. Харьяа байгууллагуудад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохицуулалтаар хангана.



2.5. Төрийн худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж чиглэл өгч сургалт мэдээллээр хангаж ажиллана.

2.6. Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхдээ тухайн удирдах ажилтны иргэдэд цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг харгалзан дүгнэх, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдах ажилтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллана.

2.7. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд нь олгоно.

2.8. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.9. Ил тод, хэмнэлттэй, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг чангатган, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулж ажиллана.

#### Гурав. Удирдах ажилтны хүлээх үүрэг

3.1. Хууль, дүрэм энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, шүүхийн маргаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг шүүхэд төлөөлж гарсан үр дүнг Улаанбаатар хотын Ерөнхий менежер болон Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцна.

3.2. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.

3.3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.

3.4. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.

3.5. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.

3.6. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлнэ.

3.7. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээг авна.

3.8. Нийслэлийн удирдлагаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.

3.9. Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.

3.10. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор



UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.

3.11. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.

3.12. Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангуулахтай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерээс өгсөн үүрэг даалгавар, бодлого шийдвэр тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.13. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн гадаад дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний явц үр дүнгийн талаар Улаанбаатар хотын Ерөнхий менежерт мэдээлэл өгч хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана.

3.14. Дараа онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, төсөл арга хэмжээний төсвийн төсөл, урсгал зардлын төсөвт Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн саналыг тусгана.

3.15. Дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах бодлого шийдвэрийн төслийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаар дамжуулан өргөн барина.

3.16. Тохижилт ногоон байгууламж, инженер, дэд бүтцийн чиглэлээр хэрэгжүүлэх онцлог ажлаа "Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгана.

3.17. Хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох" тухай 62 дугаар тогтоол, 2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлах тухай 217 дугаар тогтоол, 2020 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" батлах тухай 218 дугаар тогтоол, 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022 оны "Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 448 дугаар тогтоол, 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоол, 2021 оны "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах" тухай 360 дугаар тогтоол, 2022 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах" тухай 430 дугаар тогтоол, 2022 оны 487, 488, 490, 491 дүгээр тогтоол, 2020 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" батлах тухай 206 дугаар тогтоол, 2021 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 374 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ыг тус тус хэрэгжүүлж ажиллана.

Дөрөв. Гэрээг дүгнэх

4.1. Энэхүү гэрээний биелэлтийг улирал бүр гаргаж, дараа сарын 05-ны дотор Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.

4.2. Гэрээний хавсралт болох "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны



байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлэх бөгөөд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өгсөн үнэлгээг харгалзан үзнэ.

#### Тав. Гэрээний хариуцлага

5.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээг дутуу гүйцэтгэсэн, өмнөх үр дүнг бууруулсан, хүрэх түвшинд хүргээгүй, сахилга, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

#### Зургаа. Бусад зүйл

6.1. Гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.

6.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нэг талдаа бичгээр мэдэгдэнэ.

6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд 1 хувийг тус тус хадгална

Долоо. Гэрээ байгуулсан

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

ДОЛГОРСҮРЭНГИЙН  
СУМЬЯАБАЗАР

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ  
МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР"  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГА

МЯНГААГИЙН  
БАЯРАА

СҮРЭНХҮҮГИЙН  
САЙНБАЯР